

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 11 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 23

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
тов тогтоох тухай.

Монгол улсын компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.2 дугаар заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дугаар тогтоолоор батлагдсан хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх журам зэргийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2014 оны 12-р сарын 23-ны өдрийн 10 цагт компанийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газарт хуралдуулж компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

2.Хувьцаа эзэмшигчдэд хүргэх материалын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хурлыг зарлах өдрийг 2014 оны 11 дүгээрын сарын 24-нөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрөөр, эчнээ санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах эцсийн өдрийг 12 дугаар сарын 21-ны өдрөөр тус тус тасалбар болгохоор тогтоосугай.

4.Компанийн хувьцаан дахь төрийн өмчийн 90-н хувийг төлөөлж саналаа өгөхөөр Эрдэнэс Монгол ХХК-аас итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилсугай. .

5.Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдхүүнтэй томилсугай:
Тооллогын комиссын даргаар Д.Батмөнх СЭЗХ-ийн дарга
Гишүүдээр Д.Ганбаатар УБТГ-ын дарга
С.Боргил ХХХ-ийн менежер

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГА



Ж.БАТБОЛД

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд

санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчдийн, нэр : Овог, Нэр
 Хувьцаа эзэмшигчдийн дансны дугаар
 Санал өгөх хувьцааны тоо
 Бүртгэсэн: Үнэт цаасны компанийн нэр/.....
 Регистрийн дугаар
 Хувьцааны төрөл
 Брокерийн овог нэр

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1, Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө /Шивээ-Овоо ХК-ийн Төлөөлөгчийн газарт

Д/д	Санал авах асуудлууд:	Шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2015 оны Бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах	1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтын дагуу, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Батлагдсан бизнес төлөвлөгөөг хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг

2014 оны .. сарын өдөр

Тооллогын комиссын дарга

Гишүүд

“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2015 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6 дугаар заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1.2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зарлагдсан боловч ирц хүрээгүйн
улмаас хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 1 дүгээр
сарын 20-ны өдрийн 10 цагт компанийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газарт
хуралдуулахаар тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.18, 9 дүгээр зүйлийн 9.6-д заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр болох ээлжит бус хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Н.Энхтуяа, Дэд захирал С.Цэлмэг нарыг томилсугай.
2. "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох Төрийн өмчийн төлөөлөгчдийн удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бэлтгэлийг сайтар ханган зохион байгуулахыг төрийн өмчийн төлөөлөгч С.Цэлмэг, "Шивээ-Овоо" ХК-ийн гүйцэтгэх захирал О.Отгонбаатар нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.САЙНБИЛЭГ



“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчдийн
ажлын удирдамж

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан зөвхөн дараах асуудлыг хэлэлцэх
• Компанийн 2015 оны бизнесийн төлөвлөгөөг хэлэлцэж батлах
2. Нүүрс борлуулах болон хөрс хуулалтын үнэнд өөрчлөлт оруулах санал хэлэлцэхээс татгалзах
3. “Шивээ-Овоо” ХК-ийн 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин нь 2014 оныхоос бууруулахгүй байхаар хэлэлцэж батлах
4. Үр ашиг багатай, урсгал зардал нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахаас татгалзах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл

2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурал 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цагт компанийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газарт боллоо.

Хуралд хувьцааны 90-н хувийн эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК-ийг төлөөлж Зам тээврийн яамны хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга Н.Энхтуяа, Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирал С.Цэлмэг нар оролцов. ТУЗ-ийн гишүүн Э.Сэржбадам, урилгаар оролцлоо. Хурлын ирц 90 хувь байлаа.

Тооллогын комиссын дарга Д.Батмөнх хурлын ирцийг танилцуулав.

Д.Батмөнх: Өнөөдрийн хуралд төрийн өмчийн 90-н хувийн хувьцаа эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК-ийг төлөөлөл оролцож байна. Хурлын ирц 90 хувь байна.

Н.Энхтуяа: Жижиг хувьцаа эзэмшигчид ирээгүй байна хурлыг зарласан уу ?

С.Одбаяр: Хуулийн дагуу өдөр тутамын 3 сонин, болон компанийн веб хуудсаар зарласан байгаа. 12-р сарын 23-нд зарлагдаад ирц хүрэлгүй хойшилж компанийн хуулийн 69.3, 69,6-д заасны дагуу хуралдах гэж байна.

Н.Энхтуяа: Зарласан сонины хайчилбарыг үзүүлнэ үү мөн веб сайтан дээр тавьсан зартай танилцъя.

/ Веб сайтад байршуулсан зартай танилцав./

Н.Энхтуяа: Хурлын зарыг нийтэд мэдээлэгдсэн гэж үзээд хурлыг эхлүүлэх саналтай байна.


Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар хурлыг эхлүүлэхээр шийдвэрлэлээ.

Н.Энхтуяа: Хуралыг нээснийг мэдэгдье. ТУЗ-ийн 23-р тогтоолоор 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлахаар товлосон байна энэ асуудлаа хэлэлцнэ. Асуудал хэлэлцэхийн өмнө хурлын дэгийг танилцуулья.

Хурлын дэгийг 100-н хувийн саналаар батлав.

Хэлэлцсэн нь:**Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөний төсөл****Тэмдэглэсэн нь:**

Д.Батмөнх: 2015 оны төлөвлөгөөг танилцуулья.



Д.Батмөнх: 2015 оны төлөвлөгөөг танилцуулья.

Н.Энхтуяа: Хуулийн дагуу бизнес төлөвлөгөөг батлуулах үүрэг хүлээдэг Гүйцэтгэх захирал танилцуулах нь зүйтэй.

О.Отгонбаатар: 2015 оны бизнес төлөвлөгөөг

1. Уулын ажлын үзүүлэлтүүд

2. Борлуулалтын орлогын төлөвлөгөө

3. Үйлдвэрлэлийн зардал, ашиг алдагдал

4. Уулын ажлыг гүйцэтгэх техникүүд болон тэдгээрийн зардлын төлөвлөгөө

5. Орон тоо цалингийн сангийн төлөвлөгөө

6. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гэсэн дэс дараалалтайгаар танилцуулья.

1. Уулын ажлын үзүүлэлтийн хувьд 2015 нийт дүнгээрээ 2313,0 мянган тонн нүүрс олборлон борлуулна. Үүнээс ДЦС-4-д 1750,0 мянган тонн, Амгалангийн дулааны станцд 360,0 мянган тонн Дорноговийн Дулааны станцад 38,2 тонн гээд нийт 2313 тонн нүүрсний захиалагыг хэрэглэгчид ирүүлсэн. Энэ нь өнгөрсөн оноос 313,0 мянган тонноор нэмэгдсэн үзүүлэлт юм.

2014 онд 2,0 сая тонн нүүрс олборлож борлуулахаар төлөвлөснөө биелүүлсэн. 2015 онд тээвэртэй хөрс 2,1 саяар, тээвэргүй хөрс 500 мянгаар өсөж төлөвлөгдсөн. Мөн 2,6-6-н метрийн ззузаантай 4 давхаргын 1,1 сая м3 завсарын хөрс хуулна. Шимт хөрс 50,0 мянган тонныг хуулна. Нүүрс олборлолт карьерийн 3-33 огтлолын хооронд явагдана.

2. 2014 онд 36,7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олохор төлөвлөж биелүүлсэн бол 2015 онд 49,2 тэрбум төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн байгаа.

3. Алдагдал өнгөрсөн жил 7,2 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдөж байсан. Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 4,8 тэрбум гарахаар байгаа. 2015 оны төлөвлөгөөний анхны хувилбарт 20,0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгдөж 11-р сард ТУЗ-д танилцуулагдсан. ТУЗ-өөс зардлыг болон алдагдлыг бууруулах үүрэг өгсөн. Энэ дагуу зардлыг боломжит хэмжээнээс бага байхаар хэмжээнд бууруулж алдагдлыг 6,6 тэрбум төгрөг байхаар эцсийн хувилбарыг боловсруулан ТУЗ-д 12-р сарын 21-нд танилцуулж дэмжигдэн Хувьцаа эзэмшигчдийн ээлит бус хурлаар хэлэлцүүлэх шийдвэр гаргасан. /Зардлын төлөвлөгөөг зардал тус бүрээр танилцуулав. Хурлын материалд хавсаргав./

Товчоор хэлбэл Дизелийн түлш хасагдсан нь тээвэртэй хийх байсан хөрсний ажлаа тээвэргүй хийхээр төлөвлөсөнтэй холбоотой. Цахилгаан зардал өмнөх

жилтэй ойролцоо байгаа. Тээвэргүй хөрс өссөнтэй холбогдож бага зэрэг нэмэгдсэн. Сэлбэгийн зардал анхны хувилбараар 14,5 тэрбум байсан боловч ТУЗ-өөр хасах үүрэг өгсний дагуу зарим сэлбэг засварын ажилаа хасч мөн хөдөлгүүр авахаа больж 8,5 тэрбум болтол нь бууруулсан. Энэ нь нэг талаараа 5,0 тэрбум төгрөгөөр зардлыг бууруулж байгаа мэт боловч нөгөө талаар эрсдэлийг өсч байгаа гэдгийг албан ёсоор мэдэгдэж хурлын тэмдэглэлд оруулахыг хүсч байна.

4. Уулын ажилд ажиллах техникүүдийг танилдцуулая. 25/90, 11/70 алхагч экскаватор мөн ЭКГ5 цахилгаан экскаватор 5 ш, гидро экскаватор 5 мөн 25 автосомасвалл уулын ажилд шаардлагатай. Эдгээрийн 80 хувь нь хуучин техник байгаа зардал өсөх нэг шалтгаан болж байгаа юм.

Экскаватор болон автосомасваллуудын ашиглалтын зардлын төлөвлөгөөг 2014 оны гүйцэтгэлийн хамт нэг бүрчлэн танилцуулав.

Стандарт засварыг өөрсдөө хийх боломжгүйгээс зардал өсдөг. Өөрсдөө хийе гэж төвлөгөөнд тусган засварын төв байгуулах төндөр зарласан боловч төсөвт өртөг нь багадаад төндөрт санал ирээгүй. Төсөвт өртгөө нэмье гэсэн ТУЗ зөвшөөрөөгүй үүнийг ноднин хийсэн бол хэмнэлт их гарах байлаа.

Цаашилбал Техникийн үйлчилгээний болон дугуйны зардал нэсмэгдсэн нь шинэ машин авч байгаатай холбоотой.

Манай тээвэрийн машинуудын сэлбэгийн зардал өнгөрсөн жил 1150,0 сая байсан өмнөх жилээс 600-гаар өсгөж төлөвлөж байсан боловч сүүлийн хувилбараар 473,0 сая болгож буулгасан. Үүний шалтгаан нь ашиглалтын хугацаа дууссан 5 машиныг акталж зогсооно гэж төлөвлөсөнтэй холбоотой.

Ер нь хуучин техник жил ирэх бүр зардал нь өсдөг гэдгийг сайн ойлгох ёстой.

5. Орон тоо нэмэгдэж байгаа шалтгаан нь тэсрэх материалын үйлдвэртэй холгдож 11 хүн, шинэ техник дээр 20 хүн нэмэгдэж байгаа. 3-н ээлжээр ажиллаж байгааг 4 болгоход орон тоо 7-гоор нэмэгднэ. Ингээд 2015 онд нийт 38 орон тоо нэмэгдэхээр байна. Удирлагын орон тоог 1-ээр ч өсгөөгүй болно.

С.Цэлмэг: Тэсрэх материалын үйлдвэр байгуулснаар ямар хэмнэл гарах вэ?

О.Отгонбаатар: Жилд 500,0 сая төгрөг хэмнэнэ.

Төлөвлөгөөг үргэлжүүлэн танилцуулья. 3,0 тэрбум төгрөгөөр цалин өсч байгаа шалтгаан нь уулын ажлын өсөлтөөс 800 сая орон тооны өсөлтөөс 900 сая, үлдэх 1,5 тэрбум нь цалинг 20 хувиар өсгөхөөр төлөвлөсөнтэй холбоотой өсөлт байгаа. Бусад ижил төстэй уурхайгаас манай цалин бага байгаа тул дөхүүлэх зорилго тавьсан. Оны өмнө Багануурын цалин өссөн мэдээлэл ажлчлдын сэтгэлзүйд нөлөөлж байна. /Цалингийн зардлыг бүтэцээр нь тайлбарлав. /

6. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө танилцуулав. Галын голомт маш их үүссэн өнөөдрийн байдлаар нүүрсний нөөц багасч 2 хоног зогсоолоо. Техникийн хүрэлцээ муу байгаа учир ачигч гидро ЭКГ 2 авсан. Бусад хэрэнгийг авах эх үүсвэр байхгүй. Засгийн газарт хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ гэж төлөвлөж байна.

Н.Энхтуяа: 7-н тэрбум төгрөгийн алдагдал юунаас алдаж байна.

О.Отгонбаатар: Үнэ доогуур байгаатай холбоотой борлуулалтын орлогоор зардлаа нөхөж чаддаггүйтэй холбоотой. 2014 оны тайланд Балхан Аудит хийсэн. Ийм нөхцөлд үүнээс илүү ажиллах боломжгүй гэсэн дүгнэлтийг гаргаж өгөхөд бэлэн байгаа. Нүүрсний үнийг бодит түвшинд хүргэсэн үед алдагдал арилна. Өртөг зардал өндөр байгаагийн гол шалтгаан нь техникийн эвдрэл, түлшний зардал байдаг. Үүнийг бууруулахын тулд конвейер болон ротортой экскаваторын хосолсон систем нэвтрүүлэх хэрэгжүүлэхээр явж байгаа. Энэ систем нэвтэрвэл алдагдалгүй ажиллах боломжтой.

Н.Энхтуяа: Төлөвлөгөөнд байгаа урлаг спортын арга хэмжээний 104,0 сая. Ном хуруулах 8,0 сая, Хаялга спорт клубын зардал 27,0 сая, хэвлэл мэдээлэлийн 31,0 сая гэсэн зардлуудыг хасах хэрэгтэй.

О.Отгонбаатар: Хүнд ажил хийж байгаа хүмүүсийг баярлуулж байж ажилуулах шаардлага гардаг. Эдгээр зардал нь ажилчдын сэтгэлзүйг өргөх зардал юм. Сэтгэлзүйгээр өргөж ажилуулахын ач холбогдол нь өндөр юм. Ард нь боловсон хүчний бодлого байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй. Бүх юмыг энэ төлөвлөгөөгөөр хийхгүй хэмнэхийг хичээнэ.

Н.Энхтуяа: Удирдлагын зардалд байгаа 89,0 сая төгрөгийн сургалтын зардлын задаргааг танилцуулья. Удирдлагын сургалтанд зарцуулах юм уу?

О.Отгонбаатар: Манай компанийн зардлын ангилалаар Удирдлагын зардал дотор Сургалтын зардал ордог энэ компанийн ажилчдыг сургах зардал юм. Удирдлагын сургалтанд зарцуулах аар төлөвлөсөн зүйл байхгүй.

/ Сургалтын зардлын задаргааг нэг бүрчлэн танилцуулав. /

С.Цэлмэг: Ажилчдыг идэвхжүүлэх нь чухал энэ чиглэлийн зардлууд зайлшгүй байх ёстой гэж бодож байна. Энэ зардал дээр хэмнэлт хийснээр алдагдал дорвитой буурахгүй. Харин энэ зардлууд нь ҮЭ-ийн саналыг үндэслэж орж ирсэн байх ёстой.

Н.Энхтуяа: Техникийн асуудал дээр бодлого явуулдаг уу. Хэвлэлд төлөвлөсөн 31,0 сая өндөр байна. Сургалтын зардлыг бол ойлголоо дэмжиж байна. Урлаг спортын 104 сая дээр Хаялга спорт клубын зардал давхардаж байна.

С.Цэлмэг: Энэ төлөвлөгөө нь манай компанийн Нэгдсэн удирдлагын газраар хянагдаад ТУЗ нь хэлэлцэж дэмжигдсэн байгаа. Хяналт дүгнэлт нь хийгдсэн,

бидний зүгээс саналаа өгсөн тул төлөвлөгөөн дээр ямар нэг өөрчлөх санал байхгүй дэмжиж байна. Хэвлэл мэдээлэлийн зардлыг харин ч өсгөх ёстой. Өнөөдөр төрийн өмчийн уурхайн муу муухайг нь л мэдээлдэг. Үнэн бодит гэрэл гэгээтэй зүйлийг нийгэмд мэдээлэх хэрэгтэй байна.

Э.Сэржбадам: ТУЗ-ийн хуралд эхэлж төлөвлөгөө оруулахад нь буцааж 1 сар гаруй төлөвлөгөөг хянаж ажилласан юм. Эрдэнэс Монгол ХХК хараат бус гишүүд дэмжиж энэ төлөвлөгөөг ТУЗ-еер хэлэлцэн дэмжсэн. ТУЗ байнга хянаж явдаг тул төлөвлөгөөгөө баталъя гэсэн зөвлөмж өгч байна.

Н.Энхтуяа: Эрдэнэс Монгол ХХК болон ТУЗ саналаа хэллээ хүлээн авч байна. Гэхдээ дандаа алдагдалтай байгаад байх уу? гэдэг асуудал байна. Манай Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн зүгээс бизнес төлөвлөгөөний 2015 оны үзүүлэлтийг 2014 оноос бууруулалгүй батал гэсэн чиглэл өгсөн.

Д.Батмөнх: Өнгөрсөн онд 7,3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгөө батлагдсан. Бид зардлаа хэмнэж дотоод нөөц бололцоогоо дайчилж 5,0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвтэй байна. Энэ 2015 онд 6,4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн тул үзүүлэлт өнгөрсөн оны төлөвлөгөөнөөс буураагүй гэж ойлгож болно. Алдагдлыг өнгөрсөн оны төлөвлөгөөнөөс 1,0 тэрбум төгрөгөөр бага байхаар төлөвлөсөн. Манай алдагдал нь сүүлийн үед гарч байгаа алдагдал биш олон жил болж байгаа төрийн бодлоготой холбоотой үүсдэг зүйл.

Н.Энхтуяа: Тайлбарыг ойлголоо. Өөр асуулт байна уу?

Цэлмэг: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөн дээр санхүүжилтийг гадаад эх үүсвэрээр шийднэ гэсэн байна үүнийг шийдсэн юм байна уу?

Д.Батмөнх: Эх үүсвэр шийдэгдээгүй гэхдээ Дулааны 5-р станц баригдахтай холбогдон уурхай 2016 оноос өргөжих тул үүний бэлтгэл ажлыг хийх зорилгоор Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулсан. Асуудлыг эртхэн ойлгуулж Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-дөө танилцуулж байж шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Н.Энхтуяа: Өөр асуулт байхгүй бол асуулт хариулыг тасалж, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулья.

Д.Батмөнх: Өнөөдрийн хуралд компанийн хувьцааны 90-н хувийн төлөөлөл 2 хүн оролцож 2 саналын хуудасаар санал хураахад хүчинтэй саналын хуудас 2 байлаа.

"Шивээ-Овоо" ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн санал 100 хувь байна.

Н.Энхтуяа: Санал хураалтын дүнгийн дагуу батлагдах тогтоолын төслийг уншиж сонсгов.

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтийг 1 дүгээр хавсралтын дагуу, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан бизнес төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.БАТБОЛД/-д үүрэг болгосугай. .. гэжээ.

Тогтоолын төслийг батласнаар хурал 12 цаг 10 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЭНХТУЯА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.ОДБАЯР

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 1 дүгээр
сарын 20.-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Бизнес төлөвлөгөө батлах тухай.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2015 оны 1-р сарын 19-ны өдрийн удирдамж,
компанийн дүрмийн 11,7 дугаар заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтийг 1 дүгээр хавсралтын дагуу, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан бизнес төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.БАТБОЛД/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ЭНХТУЯА

С.ОДБАЯР



"ШИВЭЭ-ОВОО" ХК-ИЙН 2015 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дд.	Үзүүлэлтүүд	Хэм	2012 оны гүйцэтгэл	2013 оны гүйцэтгэл	2014 оны төлөвлөгөө	2014 оны хбг/гүйцэтгэл	2015 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
								Хувиар	
								2014 хбг	2015 төл
								2014 төл	2014 хбг
I Үйлдвэрлэл, Эдийн засгийн үзүүлэлт									
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт								
	Нүүрс гаргалт	м.тн	1,751.8	1,964.4	2,000.0	1,922.8	2,313.3	96.1	120.3
	Нүүрс борлуулалт	м.тн	1,723.4	1,917.0	2,000.0	2,013.8	2,313.3	100.7	114.9
	Хөрс хуулалт	м.м³	6,793.5	7,061.5	8,250.0	7,241.7	9,415.8	87.8	130.0
	дахин шидэлт	м.м³	2,009.5	1,951.6	1,740.0	3,299.8	3,350.0	189.6	101.5
	Инженерийн ажил	м.м³	383.8	660.9	550.0	472.8	1,424.0	86.0	301.2
	Нийт уулын цул	м.м³	10,911.1	11,297.6	12,432.9	12,603.4	15,082.1	101.4	119.7
2	Нийт орлого	м.төг	27,640,611.2	32,480,752.2	36,566,576.0	36,353,026.3	49,225,806.8	99.4	135.4
	Үүнээс Цэвэр борлуулалт	м.төг	27,190,377.8	31,608,061.1	36,481,200.0	36,071,748.2	49,070,431.8	98.9	136.0
	1тн нүүрсний илчлэгийн зөрүүгийн орлого	м.төг	-	-	-	-	-	-	-
3	Нийт зардал	м.төг	31,875,038.1	35,478,921.9	43,739,921.5	42,839,470.5	55,897,524.8	97.9	130.5
	Үүнээс:Удирдлагын	м.төг	1,371,330.1	1,424,942.8	2,033,626.0	1,731,763.8	2,342,023.0	85.2	135.2
4	Татварын өмнөх ашиг(алдагдал)	м.төг	(4,234,426.9)	(2,998,169.7)	(7,183,346.5)	(6,486,444.3)	(6,671,718.0)	90.3	102.9
5	Төсвийн төлбөрт:	м.төг	4,823,634.0	5,204,342.0	6,335,602.6	6,068,017.6	8,283,492.6	95.8	136.5
	а) орлогын татварт	м.төг	-	-	-	-	-	-	-
	б) НӨАТ	м.төг	2,719,037.8	3,160,806.0	3,648,120.0	3,512,344.8	4,907,043.2	96.3	139.7
	в) Бусад татварт	м.төг	2,104,596.2	2,043,536.0	2,687,482.6	2,555,672.8	3,376,449.4	95.1	132.1
6	Нийт авлага	м.төг	4,988,690.0	5,018,417.9	4,138,417.9	5,710,807.2	7,375,493.5	138.0	129.1
7	Нийт өглөг	м.төг	71,121,042.8	80,560,224.7	77,760,224.7	81,952,652.2	84,501,262.9	105.4	103.1
	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	13,347,549.0	26,848,346.6	24,048,346.6	28,240,774.1	30,789,384.8	117.4	109.0
8	Сарын дундаж цалин	м.төг	791.8	912.2	1,245.9	1,135.6	1,562.7	91.1	137.6
9	1тн нүүрсний өөрийн өртөг	төг	18,057.5	17,848.5	21,605.0	20,889.5	23,706.5	96.7	113.5
10	1тн нүүрсний дундаж үнэ	төг	15,777.0	16,488.1	18,240.6	17,912.7	21,212.3	93.2	118.4
11	1м3 уулын цулын өртөг	төг	2,852.2	2,971.0	3,475.5	3,337.7	3,638.1	96.0	108.9
12	Нийт цалингийн сан	м.төг	4,700,659.0	5,631,622.4	7,699,492.2	7,450,332.8	10,782,541.1	93.8	144.7
13	Ажилчдын тоо	хүн	495	515	515	520	569	101.0	109.4
14	Бор-ын 1 төг-т ногдох зардал	төг	1.14	1.08	1.18	1.17	1.12	98.8	95.5
15	ХО ба ТЗБАХэмжээ	м.төг	3,080,134.0	4,196,830.0	28,118,504.0	9,285,279.0	101,676,731.6	33.0	###
16	Гадаадын зээл тусламж	м.төг					96,014,880.4		
17	Өөрийн хөрөнгөөр	м.төг	3,080,134.0	4,196,830.0	28,118,504.0	9,285,279.0	5,661,851.2	33.0	61.0
II Түлш эрчим хүчний найдвартай байдал									
1	Аваар, осол / техникийн /	тоо	5.0	1.0	-	-	-	-	-
2	Хөрс хуулалтын коэффициент	м³/тн	3.9	3.6	4.2	3.8	4.1	89.0	108.1
3	Ус шүүрүүлэлт	м.куб	4,014.0	4,490.0	4,248.9	3,725.5	4,300.0	87.7	115.4
4	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	11,527.1	45,561.0	28,920.0	28,992.7	44,364.0	100.3	163.0

"ШИВЭЭ-ОВОО" ХК-ийн 2015-2016 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дд.	Хийгдэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	2015 онд хэрэгжүүлэх	2016 онд хэрэгжүүлэх	2017-2021 онд хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх нэгж	Тайлбар тодруулга	Дүнх зөвлөх хувь
Техник, технологийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалт											
Хөдлийн банкны санхүүжилт, гадаадын хөнгөлөлттэй зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ											
1.1	Олон утуурт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолто үүсгэгчийн систем	иж бүрдэл	1	46,100,000	46,100,000	6,915,000	-	39,876,500	УНХ	Өсөн нэмэгдэж буй хөрсний хэмжээг орчин үеийн хөрсний конвейерийн системээр хуулах шаардлага үүсч байна.	11.97%
1.2	Ус шүүрүүлэх D шугамын өргөтгөл	иж бүрдэл	1	10,806,456	10,806,456	6,062,431	4,744,025		УШХ	Хөрс хууралт, нүүрс олборлолт, борлуулалтын хэмжээ 2 жилийн дараа 2.2 дахин нэмэгдэх боломжтой холбоотойгоор ус шүүрүүлэлт олборлолтоосоо 2-3 жилээр түрүүлж явж байх шаардлагатай.	10.50%
1.3	Шинэ-ууны ордын нарийвчилсан хайгуулын ажил	иж бүрдэл	1	4,500,000	4,500,000	4,500,000			ТехБХ	1.1 тэрбум төгрөг 34 цоонгор өрөмдөж, тайлан зураглалын төсөв, 350.0 мянган тонн нүүрс нээх хөрс хуулаалтын зардал	7.79%
1.4	Технологи дамжлагын 2 дахь хэсэг	иж бүрдэл	1	4,488,424	4,488,424	4,488,424			ТДХ	Одоо ашиглагдаж буй технологи дамжлага 2.0 сая тонн борлуулах хүчин чадалтай өсөн нэмэгдэж буй нүүрс борлуулалтыг хангахад өргөтгөл хийх шаардлагатай.	7.77%
1.5	ЭКГ-10 цахилгаан экскаватор	иж бүрдэл	1	10,000,000	10,000,000	10,000,000			УНХ	Уурхайн одоо ашиглаж байгаа техникийн хүчин чадлаас давсан, 2476.0 мянган м/хөрс хуулаалтын ажилд зориулагдана.	17.32%
1.6	Хөрсний автосамосвал /130-136тн/	ш	3	3,500,000	10,500,000	10,500,000			АБХ	Өсөн нэмэгдэж буй отвал, нүүрсний склад, алхагч экскаваторуудад, хатаах үйлдвэр, нүүрсний конвейер тус бүрт ажиллуулахад бульдозер хэрэглэхгүй байна.	18.16%
1.7	Гинжит бульдозер 9.3 м3	ш	1	1,430,000	1,430,000	1,430,000			АБХ		2.46%
Гидро экскаватор /6А, 16Б тн/ дундаж үйлд. 3.2 м/т											
1.9	Хөрсний автосамосвал /40-60тн/	ш	3	1,200,000	3,600,000	3,600,000			АБХ	Гидро экскаваторуудын төмөр ашиглалт-ТАХ ТББК, цагийн бүтээлт тус тус буурч, эвдрэл саатлын тоо нэмэгдэж байна.	1.39%
1.10	Дугуйт ачигч 6.3 м3 /МА-600 тэй дүүцэхүйц/	ш	1	1,700,000	1,700,000	1,700,000			АБХ	Хөрс хуулаалтанд ажиллах ТАМ-ны тоо хүрэлцэхгүй, аюлын бүтээл хангах шаардлагатай.	6.23%
1.11	Хөдөлгүүр засварын багаж хэрэгсэл	иж бүрдэл	1	520,000	520,000	520,000			АБХ	Жили 2.3 сая тонн борлуулахад төмөр замын 10-р замаар агаонд ачих шаардлагатай.	2.94%
1.12	Засвар үйлчилгээнд /Б-8тн крантай машин/	ш	1	20,000	20,000	20,000			АБХ	Хөдөлгүүр засварлахад Бор өндөр УБУ, Багануур ХК, Эрдэнэт УБУ явах шаардлага гардаг, Богино хугацаанд үйлдвэр дээрээ засварлаад ажилд гаргаж байх шаардлагатай.	0.90%
1.13	Дугуйт түрэгч 7.5 м3 /МД-600 тэй дүүцэхүйц/	ш	1	1,200,000	1,200,000	1,200,000			АБХ	Техник засвар үйлчилгээнд шаардлагатай.	0.05%
										Түрэх механизмдын хүрэлцээ муудсан, одоо ажиллаж байгаа түрэгч WD-600 ашиглалтын шаардлага хангахаа больсон.	2.08%

1.14	Байгууллагын ERP систем	цогц	1	350,000	350,000	350,000	350,000	ХМА	Худалдаа хангамж, захиалгын систем, санхүү, үйлдвэрлэлийн бүртгэл мэдээлэл, хүний нөөц, төлөвлөгт, ашиглалт, архив албан бичиг баримт хөтөлгөөний уялдааг сайжруулах цахим болгоно.	0.61%
	ДҮН				96,014,880	52,085,855	4,744,025	39,876,500		90.20%
2	Технологи, техник тоног төхөөрөмжийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалт									
2.1	Хатаах үйлдвэр болон нүүрсний солейерийн нэг бутуурийн эх үүсвэрийг салгах ажил	иж бүрдэл	1	1,599,000	1,599,000	1,599,000	1,599,000	ТДХ	2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орсон арга хэмжээ	2.77%
2.2	Төлөвлөлийн программ	иж бүрдэл	1	131,480	131,480	131,480	131,480	ТехБХ	Үлдэгдэл төлбөр	0.23%
2.3	Ус шүүрүүлэх D шугамын өргөтгөлийн ТЭЗҮ	иж бүрдэл	1	240,819	240,819	240,819	240,819	ТехБХ	ТЭЗҮ хийлгэх ажлын хөлс	0.42%
2.4	Гинжит бульдозер 9.3 м3	ш	1	1,276,000	1,276,000	1,276,000	1,276,000	АБХ	2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, 2015 онд санхүүжилт хийгдэнэ. Хөрсний отвал, ЭШ-25/80, ЭШ-11/70 экскаваторын алхах талбай түрээхэд хүрэлцэхгүй тул зайлшгүй авах шаардлагатай.	2.21%
2.5	ПАЗ автобус 25-30 хүний суудалтай	ш	1	150,000	150,000	150,000	150,000	ТҮХ	Ажиллагсдын тоо нэмэгдэж байгаа тул одоогийн хүчин чадалд автобус дутмаг байна.	0.26%
2.6	ЭШ-25/80 Улирлагын систем	ком	1	1,050,000	1,050,000	1,050,000	1,050,000	УНХ	Удирдлагын тоон системтэй болгох.	1.82%
2.7	Аварын дизель станц 320 кВт, 380В	ш	1	250,000	250,000	250,000	250,000	ТДХ	Хатаах үйлдвэрт, тог тасарсан үед хатаах үйлдвэрийн сарааны суллаг.	0.43%
	ДҮН			4,697,299	4,697,299	4,697,299	-			8.13%
3	Үйлдвэрлэлийн барилга, цахилгаан хангамж болон инженерийн байгууламж, өргөтгөл засварын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалт									
3.1	110кВ ка - өн дэд станцын кахын цахилгаан байгууламж	1/к бүрэлт	2	20,000	40,000	40,000	40,000	ЦХХ	Хуурамч болон ачаалал ихтэй үед автомат горимд ажиллахгүй хэвийн ажиллагаа алдагдсан таслалт залгалт хийхгүй байгаа	0.07%
3.2	Тэсрэх бодисын үйлдвэрийн барилга, тохижуулалтын ажил	иж бүрдэл	1	314,172	314,172	314,172	314,172	ТБсҮ	Барилга тоног төхөөрөмж тавилга	0.54%
3.3	Энгийн тэсрэх бодисын зурвач компьютер	ш	1	230,180	230,180	230,180	230,180	ТБсҮ	TREAD MODEL-1	0.40%
3.5	АХЖ-742 тээвэрлэх зурвач	ш	25	25,000	25,000	25,000	25,000	ТБсҮ	Тээвэрлэх зурвач	0.04%
3.6	Сэрээт өргөгч	ш	1	20,000	20,000	20,000	20,000	ТБсҮ	Тэсрэх бодисын үйлдвэрийн ТЭЗҮ-нд тусгагдсан хөрөнгө	0.03%
3.7	Пекап	ш	1	50,000	50,000	50,000	50,000	ТБсҮ	Тэсрэх бодисын үйлдвэрийн ТЭЗҮ-нд тусгагдсан хөрөнгө	0.09%
	ДҮН			749,352	749,352	749,352	-			1.30%
4	Мэдээлэл технологийн хангамж болон инженерийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалт									
4.1	GPS/Каналтын сүлжээ	ш	40	48,000	48,000	48,000	48,000	АБХ	Автосамосуудад хяналт тавих	0.00%
	ДҮН			48,000	48,000	48,000	-			0.05%
	Бусад арга хэмжээ									
5.1	Хүний нөөцийн цогц программ	ком	1	5,000	5,000	5,000	5,000	ЗХНБХ	Мэдээлэл боловсруулалтыг сайжруулах	0.01%
5.2	Албан хэрэг хөтөлөгт, архивын программ	ком	1	4,500	4,500	4,500	4,500	ЗХНБХ	Мэдээлэл боловсруулалтыг сайжруулах	0.01%
5.3	Хөгжим аппаратур	ком	1	9,700	9,700	9,700	9,700	ЗХНБХ	Ажилчдын хөгжмийн хамтлагт зориулах	0.02%
5.4	LCD дэлгэц авах/өндөр 3м, урт 5м харьцаатай/	ш	1	8,000	8,000	8,000	8,000	ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.01%

5.5	Уурхайн танилцуулга, CD, плаш, бал, түлхүүрийн осорор захиалах	ш	800	40	32,000	32,000	32,000		ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.06%	
5.6	Том гэр	ш	1	8,000	8,000	8,000			ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.01%	
5.7	Уулын конторын өмнөх усан оргилуурыг сэргээн засварлах	ком	1	5,000	5,000	5,000			ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.01%	
5.8	"Уурхайчин өргөө" барьж байгуулах	ком	1	50,000	50,000	50,000			ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.09%	
5.9	"Бокс" "Жудо"-ын дэвжээ авах	ком	1	22,000	22,000	22,000			ЗХНБХ	Уурхайн ойн арга хэмжээнд	0.04%	
5.10	Хогийн бункер	ком	2	3,500	7,000	7,000			ЗХНБХ	Сумын ЗДТГ-аас шаардлага ирүүлсэн.	0.01%	
5.11	Notebook	ш	1	1,000	1,000	1,000			ЗХНБХ	Албан хэрэглээнд	0.00%	
5.12	Принтер	ш	2	7,500	15,000	15,000			ЗХНБХ	Албан хэрэглээнд	0.03%	
	Дүн				167,200	167,200						0.29%
	Нийт дүн				101,676,732	57,747,707	4,744,025					100.00%
	Эх үүсвэр гадны/				96,014,880	52,085,855	4,744,025					90.20%
	Эх үүсвэр Дотоод/				5,661,851	5,661,851						9.80%

“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 1 дүгээр
сарын 20.-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий 1631 хувьцаа эзэмшигчдээс нийт хувьцааны 90 хувийг эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөл болох Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Н.Энхтуяа, Дэд захирал С.Цэлмэг нар хуралд оролцож байгаа тул хурлын ирц 90 хувь байлаа.


Нийт 2 саналын хуудсаар санал хураахад хүчинтэй саналын хуудас 2 байсан.

“Шивээ-Овоо” ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтийг 1 дүгээр хавсралтын дагуу, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар батлахыг зөвшөөрсөн тогтоолын төслийг дэмжсэн санал 2 буюу 100-н хувь байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН

ДАРГА


ГИШҮҮД



Д.БАТМӨНХ

Д.ГАНБААТАР

Г.БОРГИЛ



“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

№	Хурлын арга хэмжээний дэс дараалал	Хугацаа
1	Хурлын нээлт /Хурлын ирц болон хуралд урилгаар оролцогчдыг мэдээлэх /	5 минут
2	Хуралд хэлэлцэх асуудлыг танилцуулах	
3	Хурлын дотоод журам дэгийг танилцуулж батлуулах	5 минут
4	Тооллогын комиссыг танилцуулах /Саналын хуудсаа өгөөгүй хувьцаа эзэмшигчдэд хуудсаа өгөхийг сануулах/	10 минут
5	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу асуудлыг хэлэлцүүлэх	1 цаг
6	Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуулт тавих, санал шүүмжлэл хэлэх	Хүн бүр 3 минут
7	Тавьсан асуулт, санал шүүмжлэлд хариу өгөх	Тус бүр 3 минут
8	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж тогтоолыг уншиж сонгох	15 минут
9	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулж батлуулах	10 минут
10	Хурлын хаалт	5 минут